



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/001/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор: Ө.Болортуяа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Төлбөрийн акт	9
5.1 Албан шаардлага.....	9
5.2 Зөвлөмж	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 84
тантай _____ -ны № _____ -г

ДАЛАНЗАДГАД СУМЫН 33 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.НАЦАГСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 60,870.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан, тооцооллоос шалтгаалж 2,136.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, 993.4 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон, 3,443.5 мянган төгрөгийн балансын урамшуулал цалингийн сангаас олгосон нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 35 дугаар зүйлийн 35.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин олгох журам"-ын 2.8, 2.8.1 дэх хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 5 дугаар сараас ISO:9001:2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн байна.

4626050091

F:\2.Бичиг х-р\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл Досх

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 122,948.2 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 155,393.0 мянган төгрөгийн "Нутгийн дэм" урамшуулал, 41,272.5 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл зардлын санхүүжилт олгосон байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 94.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>250,129,368.20</u>	<u>310,180,711.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	152,342,265.70	38,064,837.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	152,342,265.70	38,064,837.02
3121	Төгрөг	152,342,265.70	38,064,837.02
31211	Төрийн сангийн харилцах	152,342,265.70	38,064,837.02
33	АВЛАГА	-	2,136,656.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,136,656.52
35	БАРАА МАТЕРИАЛ	97,787,102.50	269,979,217.60
351	Түүхий эд материал	2,367,350.00	4,045,640.00
35110	Тусгай зориулалттай материал	2,068,500.00	3,005,800.00
35130	Эм боох материал	298,850.00	1,039,840.00
354	Хангамжийн материал	95,419,752.50	265,933,577.60
35410	Бичиг хэргийн материал	-	1,217,500.00
35420	Аж ахуйн материал	20,200.00	1,807,910.00
35440	Түлш, шатах тослох материал	126,500.00	26,284,100.00
35460	Хүнсний материал	11,655,402.50	7,844,617.50
35470	Бусад хангамжийн материал	83,617,650.00	228,779,450.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,778,575,358.49</u>	<u>4,089,290,929.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,778,575,358.49	4,089,290,929.12
392	Биет хөрөнгө	3,776,952,858.49	4,087,833,429.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,476,190,686.00	3,476,190,686.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(57,936,511.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,322,593.39	303,965,593.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(52,136,768.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,439,579.10	380,072,579.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(42,220,816.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	82,870,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,971,333.33)
393	Биет бус хөрөнгө	1,622,500.00	1,457,500.00
39301	Програм хангамж	1,622,500.00	1,622,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(165,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,028,704,726.69</u>	<u>4,399,471,640.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,028,704,726.69</u>	<u>4,399,471,640.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,028,704,726.69	4,399,471,640.26
512	Хуримтлагдсан үр дүн	4,028,704,726.69	4,399,471,640.26
51210	Өмнөх үеийн үр дүн	4,028,704,726.69	4,028,704,726.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	370,766,913.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,028,704,726.69</u>	<u>4,399,471,640.26</u>

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,607,229,163.23	2,197,797,789.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,978,307,663.23	937,164,789.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,978,307,663.23	937,164,789.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,977,287,590.23	937,164,789.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,730,481.74	323,793,789.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,715,470,228.21	473,800,900.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,134,250.00	139,570,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,952,630.28	-
120009	Бусад орлого	1,020,073.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,921,500.00	1,260,633,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	583,707,300.00	1,148,012,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	583,707,300.00	1,148,012,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,214,200.00	112,620,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,214,200.00	112,620,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	578,524,436.54	1,819,741,275.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,524,436.54	1,819,741,275.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	574,645,622.33	1,804,693,292.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,856,814.10	1,235,935,470.99
210101	Үндсэн цалин	244,426,349.48	764,421,100.10
210102	Нэмэгдэл	133,376,834.62	382,833,346.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	32,654,999.53
210104	Урамшуулал	16,053,630.00	56,026,024.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,775,308.14	139,723,153.17
210201	Тэтгэврийн даатгал	32,407,628.71	96,893,608.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,840,438.73	10,990,607.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,088,394.00	6,497,252.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,887,769.29	5,038,727.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,551,077.41	20,302,957.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,137,485.79	63,614,717.17
210301	Гэрэл, цахилгаан	6,052,155.79	14,115,691.17
210302	Түлш, халаалт	18,900,000.00	34,712,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,185,330.00	14,786,626.00
2105	Нормативт зардал	78,703,714.30	169,223,657.00
210502	Хоол, хүнс	78,703,714.30	169,223,657.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,255,400.00	7,800,000.00
210602	Тавилга	300,000.00	-
210604	Урсгал засвар	10,955,400.00	7,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,800.00	5,889,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	199,800.00	5,889,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,717,100.00	182,506,894.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,620,100.00	19,282,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,069,500.00	5,971,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,500.00	157,252,829.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,878,814.21	15,047,982.83

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,878,814.21	15,047,982.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,878,814.21	15,047,982.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,028,704,726.69	378,056,513.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,289,599.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	7,289,599.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,289,599.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,028,704,726.69	370,766,913.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	766,672,054.74	1,584,426,789.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,750,554.74	323,793,789.00
120	Нийтлэг татварын бус орлого	137,750,554.74	323,793,789.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,730,481.74	323,793,789.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,730,481.74	323,793,789.00
120009	Бусад орлого	1,020,073.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,921,500.00	1,260,633,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	583,707,300.00	1,148,012,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	583,707,300.00	1,148,012,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,214,200.00	112,620,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,214,200.00	112,620,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	603,149,789.04	1,697,247,117.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	603,149,789.04	1,697,247,117.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	599,270,974.83	1,682,199,134.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,856,814.10	1,238,072,127.51
210101	Үндсэн цалин	244,426,349.48	766,557,756.62
210102	Нэмэгдэл	133,376,834.62	382,833,346.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	32,654,999.53
210104	Урамшуулал	16,053,630.00	56,026,024.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,775,308.14	139,723,153.17
210201	Тэтгэврийн даатгал	32,407,628.71	96,893,608.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,840,438.73	10,990,607.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,088,394.00	6,497,252.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,887,769.29	5,038,727.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,551,077.41	20,302,957.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,137,485.79	89,772,317.17
210301	Гэрэл, цахилгаан	6,052,155.79	14,115,691.17
210302	Түлш, халаалт	18,900,000.00	60,870,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,185,330.00	14,786,626.00
2105	Нормативт зардал	89,159,116.80	165,412,872.00
210502	Хоол, хүнс	89,159,116.80	165,412,872.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,777,900.00	7,800,000.00
210602	Тавилга	2,580,000.00	-
210604	Урсгал засвар	11,197,900.00	7,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,098,800.00	5,889,400.00

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,098,800.00	5,889,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,465,550.00	35,529,265.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,757,350.00	27,747,865.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,708,200.00	7,781,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,878,814.21	15,047,982.83
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,878,814.21	15,047,982.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,878,814.21	15,047,982.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	163,522,265.70	(112,820,328.68)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,180,000.00	1,457,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,180,000.00	1,457,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,180,000.00	1,457,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,180,000.00	1,457,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,180,000.00)	(1,457,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	152,342,265.70	(114,277,428.68)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		152,342,265.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,342,265.70	38,064,837.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,028,704,726.69	4,028,704,726.69
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	4,028,704,726.69	4,028,704,726.69
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	257,116,622.41	257,116,622.41
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,285,821,349.10	4,285,821,349.10
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	4,285,821,349.10	4,285,821,349.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	4,285,821,349.10	4,285,821,349.10
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	370,766,913.57	370,766,913.57
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,656,588,262.67	4,656,588,262.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,698,460,500.00	1,260,633,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,698,460,500.00	1,260,633,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,698,460,500.00	1,260,633,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,270,637,300.00	915,535,409.83
210101	Үндсэн цалин	859,568,200.00	766,557,756.62
210102	Нэмэгдэл	382,512,700.00	60,296,628.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	32,654,999.53
210104	Урамшуулал	28,556,400.00	56,026,024.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,482,500.00	139,723,153.17
210201	Тэтгэврийн даатгал	106,227,800.00	96,893,608.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,563,600.00	10,990,607.09

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	6,282,000.00	6,497,252.85
210204	Ажилгүйдлийн даатгал	6,282,000.00	5,038,727.50
210205	Эрүүл мэндийн даатгал	25,127,100.00	20,302,957.73
2105	Нормативт зардал	224,140,400.00	165,412,872.00
210502	Хоол, хүнс	224,140,400.00	165,412,872.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,929,000.00	5,889,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,929,000.00	5,889,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,271,300.00	34,072,165.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,317,700.00	26,290,765.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,953,600.00	7,781,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,698,460,500.00	1,260,633,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,698,460,500.00	1,148,012,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	333,803,400.00	1,148,012,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	112,620,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	112,620,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		152,342,265.70
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		38,064,837.02

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,864.4 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 14,864.4 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Тайлант онд 4,107,134.80 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас төлснийг санхүүгийн үр дүнгийн тайланд ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрсөн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнтэй тулган шалгахад 937,300 төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Тайлант хугацаанд 9,820,000 төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 67,443.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 4,049.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Тайлант онд 1 албан хаагчид ажилласан хугацааны ээлжийн амралтын олговорыг 873.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "*Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин олгох журам*"-ын 2.8-д "*Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ*", 2.8.1."*ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт-2: Тайлант оны 10 дугаар сард 3 албан хаагч, 12 дугаар сард 4 албан хаагчид тус тус цалинтай чөлөө олгохдоо ажиллаагүй хугацааны хоолны нэмэгдэл болох 120,000 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Тайлант онд нярав, нягтлан бодогч нарт нийт 3,443.5 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.4.1-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай зарцуулж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт-1: Ээлжийн амралтыг олгохдоо сард 1-5 хүртэлх хоногоор 3-5 сар дамжуулан олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-д "*Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна*" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг олгож, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

Илрүүлэлт-2: Тайлант хугацаанд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлэлгүйгээр "Сэврэй номгон уул" ХХК-тай 60,870.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

Илрүүлэлт-3: Тайлант онд 2,136.7 мянган төгрөгийн цалинг буруу тооцоолж илүү олгосноор авлагатай тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд багтаан авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 4,107.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас төлснийг санхүүгийн үр дүнгийн тайланд ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрсөн	1	4,107.1	1	4,107.1			1	4,107.1				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнтэй тулган шалгахад 937.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан	1	937.3	1	937.3			1	937.3				
Тайлант хугацаанд 9,820.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	9,820.0	1	9,820.0			1	9,820.0				
ДҮН	3	14,864.4	3	14,864.4			3	14,864.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлэлгүйгээр "Сэврэй номгон уул" ХХК-тай 60,870.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан хөрөнгө худалдан авсан	1	60,870.0					1	60,870.0				
Тайлант онд 2,136.7 мянган төгрөгийн цалинг буруу тооцоолж илүү олгосноор авлагатай тайлагнасан	1	2,136.7					1	2,136.7				
Ээлжийн амралтыг олгохдоо сард 1-5 хүртэлх хоногоор 3-5 сар дамжуулан олгосон	1	0					1	0				

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 33 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

Нягтлан бодогч, нярав нарт 3,443.5 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон	1	3,443.5			1	3,443.5						
Тайлант онд 1 албан хаагчид ажилласан хугацааны ээлжийн амралтын олговоргыг 873.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон	1	873.4	1	873.4								
10 дугаар сард 3 албан хаагч, 12 дугаар сард 4 албан хаагчид тус тус цалинтай чөлөө олгохдоо ажиллаагүй хугацааны хоолны нэмэгдэл болох 120.0 мянган төгрөгийг олгосон	1	120.0	1	120.0								
Дүн	6	67,443.6	2	993.4	1	3,443.5	3	63,006.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,063,584.2 мянган төгрөгийн 61 орлогын гүйлгээг мэдээлээгүй	1	1,063,584.2			1	1,063,584.2		
Дүн	1	0			1	0		